



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар АР/24

Өлгий

Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай  
зөвшөөрөл олгох, хүсэлтийг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.3, 19.5, Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3, 5.5, 8.1 дүгээр зүйлийн 13 дугаар жагсаалтын 13.8, 13.9, 13.10, 13.11, 13.12, 13.14, 13.15, 13.19, 13.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн комиссын 2024 оны 12 дугаар сарын 03-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрлийн эрх шинээр олгох, зөвшөөрөл нь дэмжигдсэн байгууллагуудын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, клиник, эмийн санд тавигдах стандарт шаардлагуудыг ханган ажиллахыг тусгай зөвшөөрөл авсан эрүүл мэндийн байгууллагуудад даалгасугай.

3. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл хүссэн эмийн сан, клиникүүдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход баримтлах чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Тусгай зөвшөөрөл олгох комиссын ажлын албад үүрэг болгосугай.

ДАРГА



Н.САКЕН

Эрүүл мэндийн газрын даргын  
2024 оны 12 сарын 04 өдрийн 1/84 тоот  
тушаалын 118/2024 хавсралт

**НЭГ. МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХ ШИНЭЭР  
ОЛГОСОН БАЙГУУЛЛАГА:**

| № | Байгууллагын<br>нэр       | Үйл ажиллагааны<br>чиглэл            | Хугацаа  | Хүчинтэй<br>хугацаа |
|---|---------------------------|--------------------------------------|----------|---------------------|
| 1 | "Хуст Арал<br>Трейдл" ХХК | "ММ-MED" чих хамар<br>хоолойн клиник | 3 жилээр | 2027.12.03          |

**ХОЁР.МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ НЬ  
ДЭМЖИГДСЭН БАЙГУУЛЛАГА:**

1.Өлгий сумын 11-р баг "Ер Фа Ай Ар" ХХК-ийн "Могойт-2" эмийн сан нээх  
төсөл

**ГУРАВ.НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ:**

1."Тенгри Өлгий" ХХК-ийн "Тенгри Мед" Соронзон резонанс томографи /MRI/,  
хэвлийн эхо, зүрхний эхоны кабинет байгуулан ажиллаж байгаа ба оношилгооны  
клиник үйл ажиллагаандаа нэмэлтээр "Тархины судасны өнгөт хэт авиан оношилгоо  
/Допплерография/, "Тархины цахилгаан бичлэг /ЭЭГ/ зэрэг мэдрэлийн өвчний  
оношилгоог бүрэн төрөлжүүлэн ажиллах хүсэлт.